

**МОНГОЛ УЛСЫН ЭМЭГТЭЙ БИЗНЕС
ЭРХЛЭГЧДИЙН ТОГТВОРТОЙ
САНХҮҮЖИЛТИЙГ ДЭМЖИХ ЗАМААР
БАНКУУДЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ
БОЛОМЖИЙН СУДАЛГАА**



**МОНГОЛ УЛСЫН ЭМЭГТЭЙ БИЗНЕС
ЭРХЛЭГЧДИЙН ТОГТВОРТОЙ
САНХҮҮЖИЛТИЙГ ДЭМЖИХ ЗАМААР
БАНКУУДЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ
БОЛОМЖИЙН СУДАЛГАА**

**САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИАЛГАТ СУДАЛГАА**

СУДАЛГААНЫ БАГИЙН ГИШҮҮН: А. Алгирмаа /МВА оюутан/

ТОВЧ ХУРААНГУЙ

Манай улсын хувьд эмэгтэй бизнес эрхлэгчдийн дийлэнх нь ЖДҮ-ийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжсэнээр эдийн засаг хурдтай тэлж, нийгэм дэх олон асуудлууд шийдэгдэнэ гэж үзэж байна. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд тулгамдаж буй гол асуудал нь санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмжийн асуудал байсаар байна.

Монголын санхүүгийн салбар тэр дундаа 90 гаруй хувийг дангаар бүрдүүлж буй банкны салбар нь тогтвортой хөгжил, нийгэмд чиглэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгож, тогтвортой санхүүжилтийг бий болгоход манлайлсаар байна. Банкны бүтээгдэхүүн үйлчилгээгээр дамжуулан жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засаг оруулах хувь нэмрийг нь дээшлүүлэхэд жендэрийн онцлогт тохирсон санхүүгийн болон санхүүгийн бус бүтээгдэхүүн үйлчилгээ зайлшгүй шаардлагатай байна.

Судалгааны хүрээнд Монгол улсын ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдийн өнөөгийн нөхцөл байдал, тэдгээрийн тогтвортой санхүүжилтийн хүрээнд тулгамдаж буй асуудлыг “жендэрийн эрх тэгш байдлыг хангах” зорилгын хүрээнд олж илрүүлэх, түүнд банкуудын оролцоог нэмэгдүүлэх боломжийг судлахыг зорилоо.

Судалгаанд чанарын болон гадаадын улс орны бодит кейс судалгааг судлан өөрийн улстай харьцуулах аргыг ашигласан.

Чанарын судалгааны аргаар Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа тухайн байгууллагынхаа эзэмшигч болон захирал ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдээс цахим флатформ болон анкетийн арга ашиглан асуулгын аргаар түүвэр судалгаа авсан. Асуулгын судалгаагаар ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдийн тогтвортой санхүүжилтэд тулгарч буй асуудал, шийдвэрлэх боломжийг гаргаж ирэхийг зорьсон.

Гадаадын улс орны кейс судалгаагаар Зүүн ази, Номхон далайн бүс нутгийн Монгол улстай ДНБ-ийн өсөлтийн хувьд ойролцоо улсууд, Олон улсад хийгдсэн судалгаагаар ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдийн сайн туршлага болсон улс орнуудыг сонгон ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдийн тогтвортой санхүүжилтийн нөхцөл байдал, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний жендэрийн хүртээмжтэй байдал, болон банкуудын зүгээс дэмжиж байгаа аргуудыг өөрийн улстай харьцуулах замаар дүгнэж, санал зөвлөмж гаргасан.

ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдийн тогтвортой санхүүжилтэнд тулгамдаж буй асуудлыг санал асуулгын аргаар тодорхойлж, үр дүнг SPSS программын түвшинд боловсруулав.

ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдийн тогтвортой санхүүжилтийг дэмжих, жендерийн мэдрэмжтэй санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ гаргах, бизнесээ тогтвортой явуулахад нь санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэх шаардлагатай байна. ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдийг чадавхжуулах хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх ба санхүү, татвар зэрэг бизнесийн сургалтыг явуулах, бэлэн мөнгөний менежмент, мөнгөн урсгалаа хэрхэн удирдах зэрэг сургалтыг СЭЗИС-ийн ахисан түвшний сургууль, OPS-HUB-тай хамтран зохион байгуулах боломжууд байна.

Жижиг, дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засагт үзүүлж буй нөлөө

НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр болон АХБ, ЗГ хамтарсан судалгаагаар Монгол улсад эмэгтэйчүүд ЖДҮ салбарт давамгайлан үйл ажиллагаа явуулдаг бөгөөд эмэгтэйчүүдэд бизнесээ амжилттай явуулахад санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлэх хэрэгцээ шаардлага байна гэсэн үр дүн гарсан байна. *(НҮБ, АЗХБ 2021)* НҮБ болон тогтвортой санхүүгийн холбооны санхүүгийн холбооны судалгаагаар Монгол улсын банкууд жендерийн эрх тэгш байдлыг хангах асуудлаар аль хэдийн хүчин чармайлт гаргаж эхэлсэн ба санхүүгийн салбарт жендерийн эрх тэгш байдлыг хангах хангалттай нөөц байна гэж дүгнэсэн. *(НҮБ МТСХ 2021 он)* Азийн сангийн эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх төслийн хүрээнд хийгдсэн судалгаанд эмэгтэйчүүдэд зориулсан хүртээмжтэй санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ шаардлагатай, мэдээлэл мэдлэгийг нь дээшлүүлэх санхүүжилт авахад туслах инкубатор төвүүд шаардлагатай гэж үзжээ. Эдийн засгийн бодлого өрсөлдөх чадварын судалгааны төв болон ЕСББ, (Wi B) хөтөлбөрөөс хийсэн үнэлгээний тайланд Монгол улсын засгийн газар ЖДҮ-ийн дэмжих хууль эрх зйн орчныг бүрдүүлж, сайжруулж байгаа ч жендерийн мэдрэмжтэй болж чадаагүй байна. Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээ тусгаагүй байна. Хууль эрх зүйн орчин дутмаг, төрийн үйлчилгээ авахад хүндрэлтэй байна гэжээ. *(ЭЗБӨЧСТ, ЕСББ, WIB 2021 он)* Аливаа улс орны эдийн засгийн хөгжилд эмэгтэй хүн чухал үүрэгтэй ба тэр дундаа эмэгтэйчүүд бизнесийг чадварлагаар удирддаг гэжээ. Эмэгтэйчүүдийн удирддаг аж ахуйн нэгжүүд дэлхий даяар тогтвортой хөгжиж, өрхийн орлого, үндэсний эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулж байна. *(Kalpana Ambepitiya 2016 он)* Global entrepreneurship Monitor-с хийгдсэн Эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлт 2020/2021 хямралыг даван туулах нь судалгааны ажилд дэлхий дээр ойролцоогоор 3 бизнес эрхлэгчдийн 1 нь

эмэгтэй бизнес эрхлэгч байна гэж үзсэн бөгөөд, бизнес эрхлэгч эмэгтэйчүүд дэлхийн эдийн засаг, нийгэмд томоохон хувь нэмэр оруулж байгааг харуулсан. Олон улс оронд эмэгтэйчүүд бизнес эрхлэх хүсэл эрмэлзэлтэй хэдий ч жендерийн ялгаатай байдал, ядуурал, итгэл үнэмшил олон нийтийн оролцоо хязгаарлагдмал зэргээс ихээхэн бэрхшээлтэй тулгардаг гэж дүгнэжээ. (АХБ 2020 он)

Жижиг, дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн тухай ойлголт болон өнөөгийн байдал

Тогтвортой хөгжил ба Монгол улс

Тогтвортой хөгжил гэдэг нь өнөө үеийн хэрэгцээг хангахдаа ирээдүй үеийн хэрэгцээг хангах боломжийг хязгаарлахгүй байх явдал юм. манай улсын хувьд ТХ-ийн зорилгыг хэрэгжүүлэхээр 2030 он хүртэлх “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”-ийг батлан гаргаж, арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Монгол Улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсч байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болох зорилготой.

Тогтвортой санхүү

Тогтвортой санхүү гэдэг нь эдийн засаг, байгаль орчин, нийгмийн хүчин зүйлсийг харгалзан хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах гэж тодорхойлсон байна. Монгол улсад 2017 онд “Тогтвортой санхүүгийн холбоо” нь санхүүгийн салбар болон бизнесийн байгууллагуудад байгаль орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагааг нэвтрүүлэх, тогтвортой санхүү, ногоон зээл, хөрөнгө оруулалтын дэд бүтэц бүрдүүлж, тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн өсөлтийг бий болгох зорилготой байгуулагдсан.

Тогтвортой хөгжил ба жендерийн эрх тэгш байдал

Жендерийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг дээшлүүлэхэд хувийн байгууллага болон төр засгийн зүгээс зөв санхүүжилт чухал. Эмэгтэйчүүдийн эдийн засгийг чадавхжуулах, хөрөнгө оруулалт хийх, жендерийн тэгш байдлыг хангах, ядуурлыг арилгах нь эдийн засгийн хүртээмжтэй өсөлтөд шууд хамаарна. Гэвч дэлхий даяар эмэгтэйчүүд ядуурал, ялгаварлан гадуурхалт, мөлжлөгт өртөж байгаа байдал их байна. Жендерийн ялгаварлан гадуурхалт гэдэг нь эмэгтэйчүүд найдваргүй, бага цалинтай ажилд орох, удирдах албан тушаалтны цөөнхийг бүрдүүлэх мөн эдийн засаг, нийгмийн бодлого боловсруулахад хязгаарлагдмал байдал юм.

Жижиг дунд үйлдвэрлэл ба Жижиг дунд үйлдвэр эрхлэгч эмэгтэйчүүд

ЖДҮ эрхлэгчийн тодорхойлолт 1993 оноос хойш өөрчлөгдөж явсаар хамгийн сүүлд 2019 онд шинэчлэгдэж 200 хүртэл ажилтантай, жилийн борлуулалтын орлого 2.5 тэрбум төгрөг хүртэл байхаар тодорхойлсон байдаг. ЖДҮ эрхлэгчдийн хувьд ДНБ-ийн 15.8%-ийг бүрдүүлж, нийт ажлын байрны 57%-ийг хангаж байна. 2016 онд хойш ЖДҮ эрхлэгчдийн тоо 49.1 мянга байсан бол тасралтгүй өссөөр 2019 онд 63.1 мянга болжээ. ЖДҮ эрхлэгчдийн хувьд бөөний худалдаа, үйлчилгээний салбарт ихэвчлэн үйл ажиллагаагаа явуулж байна. Манай улсын хувьд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн дийлэнх нь бичил, жижиг, дунд бизнес эрхэлдэг бөгөөд ЖДҮ эрхлэгч нарын 68 хувь нь эмэгтэй захиралтай байна. Монгол банкнаас 2018 онд ЖДҮ эрхлэгчдийг дэмждэг байгууллагуудын талаар судалгаа явуулсан бөгөөд судалгааны үр дүнгээс харахад арилжааны банкууд ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмжиж байна. Харин ЗГ-ын ЖДҮ эрхлэгчдэд үзүүлж буй дэмжлэг, ЖДҮХС-ын дэмжлэг ЖДҮ эрхлэгчдэд хүрэлцээгүй байдаг байна. Мөн олон улсын төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилт олгогдож байгаа боловч санхүүжилт хүрэлцээгүй, ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдэд мэдээлэл дутмаг байдаг байна. Монгол улсын ЗГ-аас ЖДҮ эрхлэгчдэд үзүүлж буй дэмжлэг, ЖДҮХС-ын дэмжлэг ЖДҮ эрхлэгчдэд хүрэлцээгүй байдаг байна. 2019 онд ЖДҮ-ийг дэмжих сангаас эмэгтэй захиралтай ЖДҮ эрхлэгчдэд 234 төсөл 37.4 тэрбум төгрөгийг санхүүжүүлсэн ба 2020 онд 107 төсөл 9.7 тэрбум төгрөг болж буурсан байна.

Жижиг дунд үйлдвэрлэл болон Жижиг дунд үйлдвэр эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжигч байгууллагууд

- ❖ Жижиг, дунд үйлдвэрийн газар
- ❖ Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн яам
- ❖ Мэргэжлийн бизнесийн сүлжээ
- ❖ Олон улсын санхүүгийн корпораци
- ❖ Азийн хөгжлийн банк
- ❖ Европын сэргээн босголтын банк болон Хөгжил
- ❖ Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага
- ❖ АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг
- ❖ Азийн сан зэрэг байгууллагууд байна. Эдгээр байгууллагуудаас гадна ЖДҮ

эрхлэгчдэд сургалт зөвлөгөө өгдөг төвүүд үйл ажиллагаа явуулж байгаа боловч хүртээмжгүй хэвээр байна.

Арилжааны банк

ЖДҮ эрхлэгчдийн хувьд санхүүжилт авах олон төрлийн эх үүсвэр байдаг боловч ихэвчлэн арилжааны банкнаас зээл авч санхүүждэг байна. Монгол банкнаас 2018 онд ЖДҮ эрхлэгчдийг дэмждэг байгууллагуудын талаар судалгаа явуулсан бөгөөд судалгааны үр дүнгээс харахад арилжааны банкууд ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмждэг байна.

Монгол улсад нийт 12 арилжааны банк, 1 төв банктай үйл ажиллагаа явуулж байна. Банк санхүүгийн салбар нь нийт санхүүгийн салбарын 90 гаруй хувийг дангаар эзэлдэг томоохон салбар. Тиймдээ ч тогтвортой хөгжлийг банк санхүүгийн салбараар дамжуулан хэрэгжүүлэх нь үр дүнтэй байна.

Харилцах, хадгаламжийн данс-Харилцах, хадгаламжийн данс эзэмшигчдийн хувьд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эзлэх хувь ойролцоо байгаа боловч зээлийн дансны хувьд эмэгтэйчүүд өндөр байна. Зээлийн үлдэгдлийн хувьд эмэгтэй зээлдэгч нар 4.4 их наяд төгрөг, эрэгтэй зээлдэгч нар 5,8 их наяд төгрөг байгаа бөгөөд эрчүүд 1.4 их наяд төгрөг 24 хувиар их байна

Банканд зээлтэй харилцагч нар-Зээлтэй харилцагч нарын 57 хувь нь эрэгтэй, 43 хувь нь эмэгтэй байгаа бөгөөд чанаргүй зээлийн 60 хувийг эрэгтэй зээлдэгч, 40 хувийг эмэгтэй зээлдэгч нар тус тус эзэлж байна.

Зээлийн үлдэгдэл-Эмэгтэй зээлдэгч нар 4.4 их наяд төгрөг, эрэгтэй зээлдэгч нар 5.8 их наяд төгрөг байгаа бөгөөд эрчүүд 1.4 их наяд төгрөг 24 хувиар их байна.

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн зээл-ЖДҮ эрхлэгчдийн 64 хувь нь эрэгтэй, 36 хувь нь эмэгтэй зээлдэгч байна. Чанаргүй зээлийн хувьд 67 хувийг эрэгтэй, 33 хувийг эмэгтэй зээлдэгч нар тус тус эзэлж байна. Эмэгтэйчүүд банканд бүх төрлийн данс эзэмшиж байгаа боловч жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч эмэгтэйчүүдэд олгосон зээлийн хэмжээ эрчүүдийнхээс бага буюу ердөө 36 хувийг эзэлж байна. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн 68 хувь нь эмэгтэй өмчлөгтэй байгаа боловч санхүүгийн хүртээмжийг бүрэн дүүрэн авч чадахгүй байна. Арилжааны банкуудын хувьд 2020 оноос эхлэн эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан зээлийн бүтээгдэхүүн гаргаж эхэлсэн ба системийн нөлөө бүхий 5 банкны 4 нь эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан зээлийн бүтээгдэхүүнтэй байна. Жижиг, дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн хувьд санхүүжилтийн хүртээмжгүй байдал, зээлийн олон төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээний сонголт байхгүй байна. Мөн бизнес эрхлэгчдэд сургалт, зөвлөгөө өгөх төвүүд байдаггүй.

(Эх сурвалж: Монгол банк мөнгө санхүү статистик 2021)

СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ, АРГАЧЛАЛ

Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдийн санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, арилжааны банкуудын зүгээс дэмжих боломжийг судлахад оршино.

Микро орчны шинжилгээ:

Чанарын судалгаа: Жижиг, дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдээс (байгууллагын 50 болон түүнээс дээш хувийг эзэмшдэг, байгууллагын захирал) авсан чанарын судалгаа авсан.

Энэхүү судалгааны судлах болон шинжлэх үзэгдлүүд нь тоон чанарын утгаар илэрхийлэгдээгүй. Судалгааны асуулгын хариултыг үндэслэн жижиг, дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн санхүүгийн тогтвортой байдалд тулгамдаж буй бэрхшээлийг бодит байдал, учир шалтгааныг судлана.

Асуулгын арга: Судалгааг Улаанбаатар хот, Дархан, Эрдэнэт хотод үйл ажиллагаа явуулж байгаа 98 жижиг, дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдээс (байгууллагын 50 болон түүнээс дээш хувийг эзэмшдэг, байгууллагын захирал) авсан ба асуулга нь дараах 3 хэсгээс бүрдэнэ.

Үүнд:

- Үндсэн мэдээлэл
- Бизнесийн үйл ажиллагаа, тулгарч буй бэрхшээл, үр дүнтэй аргууд
- Санхүүгийн болон санхүүгийн бус бүтээгдэхүүн үйлчилгээний хэрэгцээ шаардлага

Судалгаанд ашигласан өгөгдлийн хувьд:

Анхдагч өгөгдөл: Жижиг, дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдээс (байгууллагын 50 болон түүнээс дээш хувийг эзэмшдэг, байгууллагын захирал) авсан асуулгын судалгаа.

Ашигласан программ хангамжууд:

- SPSS-Тоон мэдээллийг статистик аргаар боловсруулдаг программ. Программын түвшинд асуулгын үр дүнгээ нэгтгэн боловсруулж, дүн шинжилгээ

хийнэ.Судалгааны ажлын статистик шинжилгээ хийхдээ солбилцлийн шинжилгээний аргыг ашигласан.

Макро орчны шинжилгээ

Гадаадын улс орны кейс судалгаагаар Зүүн ази, Номхон далайн бүс нутгийн Монгол улстай ДНБ-ийн өсөлтийн хувьд ойролцоо улсууд, Олон улсад хийгдсэн судалгаагаар ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдийн сайн туршлага болсон улс орнуудыг сонгон ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдийн тогтвортой санхүүжилтийн нөхцөл байдал, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний жендэрийн хүртээмжтэй байдал, болон банкуудын зүгээс дэмжиж байгаа аргуудыг өөрийн улстай харьцуулах замаар дүгнэж, санал зөвлөмж гаргана.

ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Судалгааны үр дүн-Судалгааг нийт 98 ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдийг хамруулан тогтвортой санхүүжилтийг бий болгоход тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх боломжийг гаргаж ирэхийг зорьсон. Судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгч нарын хувьд үйл ажиллагааны чиглэл, үйл ажиллагаа эрхэлсэн хугацаа, ажилтны тоо, борлуулалтын орлого зэргээс үл хамааран:

- Санхүүжилт авах боломжгүй, зээл хөрөнгө оруулалтын хүртээмжгүй;
- Хөрөнгө,барьцаа хөрөнгийн дутагдал;
- Бизнес хөгжүүлэх менежментийн чиглэлээр ур чадвар дутмаг;
- Нийгмийн болон бизнес дэх жендэрийн, эмэгтэйчүүдийн талаарх хэвшмэл ойлголт;
- Төр засгийн зүгээс хууль эрх зүй, хөрөнгө оруулалт дутмаг, дэмжлэг байхгүй гэсэн нийтлэг бэрхшээлүүд тулгарч байна.

ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдэд тогтвортой үйл ажиллагаа явуулахад нь санхүүжилтийн хүртээмжгүй байдал, бизнес төлөвлөгөө боловсруулахад туслалцаа шаардлагатай мөн мэргэжилтнүүдтэй харилцаа холбоо тогтооход хүндрэлтэй байдаг бол тогтвортой санхүүжилтийн эх үүсвэр олж авахад барьцаа хөрөнгийн хүрэлцээгүй байдал, зээлийн хүү өндөр, эргэн төлөх хугацаа богино байдаг асуудлууд түгээмэл байна. Цаашлаад банк санхүүгийн байгууллагуудаас зээлийн бүтээгдэхүүн авахаас гадна санхүүгийн зөвлөгөө мэдээлэл авах, бизнесээ өргөжүүлэхэд туслах үйлчилгээ авах хэрэгцээ байгаа нь судалгаагааны үр дүнгээс харагдаж байна.

Кейс судалгаа-ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүд тухайн улс орныхоо эдийн засгийг хөгжилд томоохон хувь нэмэр оруулж байна. ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүд гэсэн тодорхойлолт ангилал улс орнуудад байхгүй бөгөөд тэд байгууллага болон нийтлэг ЖДҮ-ийн ангилалаар тодорхойлогдож байна. ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүд улсынхаа нийт бизнес эрхлэлтийн 70 хувиас дээш хувийг бүрдүүлдэг ба үйлчилгээний салбарт дийлэнх нь үйл ажиллагаа явуулж байна. Мөн аль улсад үйл ажиллагаа явуулж байгаагаас үл хамааран санхүүжилт болон мэдээ, мэдээллээр дутмаг байдаг. Бизнес эрхлэхэд тулгарч буй санхүүгийн бэрхшээлийг олон янзын аргаар даван туулж байгаа боловч арилжааны банкнаас санхүүжилт авах нь хамгийн элбэг байдаг байна. Санхүүжилт авахад тулгардаг бас нэг бэрхшээл нь барьцаа хөрөнгө бөгөөд эмэгтэйчүүд өөрсдийн нэр дээр үл хөдлөх хөрөнгө бүртгүүлэхээс илүүтэй гэр бүлийн хүний нэр дээр бүртгүүлдэгтэй холбоотойгоор хүндрэл үүсдэг. Энэтхэг улсын хувьд эмэгтэйчүүддээ хөрөнгө худалдан авч бүртгүүлсэн тохиолдолд шимтгэл хураамжаас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх замаар хөрөнгөтэй болохыг нь дэмжсэн хөтөлбөр явуулж, эмэгтэйчүүд санхүүжилт хэрэгцээтэй үед хөрөнгөө барьцаалан зээл авах, бизнесийн үйл ажиллагаагаа тогтвортой явуулах боломжоор хангасан. Улс орон бүрд арилжааны банкуудын бизнес эрхлэгч эмэгтэйчүүддээ зориулсан санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээг үзүүлж байгаа боловч, хүртээжгүй байсаар байна. Арилжааны банкуудын зүгээс барьцаа хөрөнгөгүй зээл олгох асуудлыг ихэвчлэн шийдвэрлэж, цахим хэтэвчийн үйлчилгээгээр дамжуулан бүх төрлийн үйлчилгээ авахдаа шимтгэл хураамжаас чөлөөлөх зэрэг арга хэмжээг авч байна. Санхүүгийн бус үйлчилгээг ихэвчлэн ОУБ-уудтай хамтран хэрэгжүүлдэг нь судалгаагаар харагдаж байна.

Монголлын арилжааны банкуудын ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдийг тогтвортой санхүүгийн болон санхүүгийн бус бүтээгдэхүүнээр дэмжих боломжууд

ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудлууд болон ОУ-ын кейс харьцуулсан судалгаанаас Монгол улсын арилжааны банкуудын үйл ажиллагаандаа дараах бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэн ажиллах боломжууд байна. Үүнд:

[ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулсан зээл болон бусад үйлчилгээ](#)

- Банкны том зээлдэгч нарын хувьд санхүүжилтийн хэрэгцээ, мөнгөн гүйлгээ, бараа материал, орлого зэрэг санхүүгийн үзүүлэлтүүдэд тулгуурлан зээлийн хэмжээ, хугацааг тооцон санал болгох;

- Банктай олон жилийн хугацаанд хамтран ажилласан сайн харилцагч нарынхаа зээлийн түүхийг үндэслэн тодорхой зээлийн лимитийн хүрээнд барьцаагүй зээлийг онлайнаар олгох;
- Зөвхөн үл хөдлөх хөрөнгийг барьцаалах бус хөдлөх хөрөнгийг барьцаанд тооцож авах. Тоног төхөөрөмж, дансны орлого, дансны авлага, худалдан авах гэрээ, машин механизм гэх мэт шинэлэг арга барилыг судлан нэвтрүүлэх нь эмэгтэйчүүдэд тулгардаг барьцаа хөрөнгийн асуудлыг шийдвэрлэхэд туслана.

ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдийн жирэмсний амралттай үеийн хөнгөлөлт

- Зээлийн үлдэгдэлтэй ЖДҮ эрхлэгч эмэгтэй жирэмсний амралтаа авсан бол эргэн төлөлтийн хувиарыг харилцагчтай тохиролцсоны дагуу 6 сар хүртэл хугацаанд үндсэн төлбөрөөс чөлөөлөх;
- Шинэ төрсөн хүүхдийн хадгаламжийн бүтээгдэхүүнийг хүүхэд 2 нас хүртэл хугацаанд суурь тодорхой хувиар нэмэгдүүлэх;

ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулсан багц үйлчилгээ

- Арилжааны банкуудын зүгээс өөрийн харилцагч болон зах зээл дээрх харилцагчийн хэрэгцээ шаардлагыг сайтар судалж эмэгтэйчүүдийн хувийн болон мэргэжлийн хэрэгцээ шаардалгад нийцсэн багц бүтээгдэхүүнийг багтаасан үнэ цэнэ бүхий санал боловсруулах.

ЖДҮ эрхлэгчид зориулсан санхүүгийн бус үйлчилгээ

ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих инкубатор төвийг банкууд байгуулах шаардлагатай. Төвийн үйл ажиллагааны чиглэл нь:

- Банканд ирж зөвлөгөө мэдээлэл авах боломжгүй харилцагч нартаа зориулан санхүүгийн бус үйлчилгээний платформ шинээр бий болгож, бүтээгдэхүүн үйлчилгээний танилцуулга, тусгай саналуудыг багтаасан байх ба мэргэжлийн зөвлөхүүдтэй холбоо барих боломжийг олгодог байх.
- ОУСК болон Дэлхийн банкны We-Fi төсөл хөтөлбөрүүдэд хүсэлт гарган санхүүжилт татах, эмэгтэйчүүдэд зориулсан хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх;
- Арилжааны банкууд өөрсдийн албан ёсны вэб хуудсаар дамжуулан санхүүгийн мэдээлэл хүргэх, санхүүгийн мэргэжилтнүүдтэй уулзаж туршлага зэргийг нь ярилцаж ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүддээ зориулсан Podcast хийх;

- ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдийг чадавхжуулах хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх. Хөтөлбөрт санхүү, татвар зэрэг бизнесийн сургалтыг явуулах, бэлэн мөнгөний менежмент, мөнгөн урсгалаа хэрхэн удирдах сургалтыг явуулах, бэлэн мөнгөний менежмент, мөнгөн урсгалаа хэрхэн удирдах сургалтыг СЭЗИС-ийн ахисан түвшний сургууль, OPS-HUB-тай хамтран зохион байгуулах боломжууд байна.

ДҮГНЭЛТ

Судалгааг нийт 98 ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдийг хамруулан тогтвортой санхүүжилтийг бий болгоход тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх боломжийг гаргаж ирэхийг зорьсон. Судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгч нарын хувьд үйл ажиллагааны чиглэл, үйл ажиллагаа эрхэлсэн хугацаа, ажилтны тоо, борлуулалтын орлого зэргээс үл хамааран

- Санхүүжилт авах боломжгүй, зээл хөрөнгө оруулалтын хүртээмжгүй;
- Хөрөнгө, барьцаа хөрөнгийн дутагдал;
- Бизнес хөгжүүлэх менежментийн чиглэлээр ур чадвар дутмаг;
- Нийгмийн болон бизнес дэх жендэрийн, эмэгтэйчүүдийн талаарх хэвшмэл ойлголт;
- Төр засгийн зүгээс хууль эрх зүй, хөрөнгө оруулалт дутмаг, дэмжлэг байхгүй гэсэн нийтлэг бэрхшээлүүд тулгарч байна.

ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдэд тогтвортой үйл ажиллагаа явуулахад нь санхүүжилтийн хүртээмжгүй байдал, бизнес төлөвлөгөө боловсруулахад туслалцаа шаардлагатай мөн мэргэжилтнүүдтэй харилцаа холбоо тогтооход хүндрэлтэй байдаг бол тогтвортой санхүүжилтийн эх үүсвэр олж авахад барьцаа хөрөнгийн хүрэлцээгүй байдал, зээлийн хүү өндөр, эргэн төлөх хугацаа богино байдаг асуудлууд түгээмэл байна. Цаашлаад банк санхүүгийн байгууллагуудаас зээлийн бүтээгдэхүүн авахаас гадна санхүүгийн зөвлөгөө мэдээлэл авах, бизнесээ өргөжүүлэхэд туслах үйлчилгээ авах хэрэгцээ байгаа нь судалгаагааны үр дүнгээс харагдаж байна.

Гадаадын улс кейс судалгаа нийт улс орнуудын хувьд нийтлэг асуудлууд:

ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүд тухайн улс орныхоо эдийн засгийг хөгжилд томоохон хувь нэмэр оруулж байна. Хэдий тийм ч гэсэн ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүд гэсэн тодорхойлолт ангилал улс орнуудад байхгүй бөгөөд тэд байгууллага болон нийтлэг ЖДҮ-ийн ангилалаар тодорхойлогдож байна. ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүд улсынхаа нийт бизнес эрхлэлтийн 70 хувиас дээш хувийг бүрдүүлдэг. ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүд үйлчилгээний

салбарт нийтлэг үйл ажиллагаа явуулж байна. Мөн аль улсад үйл ажиллагаа явуулж байгаагаас үл хамааран санхүүжилт болон мэдээ, мэдээллээр дутмаг байдаг. Бизнес эрхлэхэд тулгарч буй санхүүгийн бэрхшээлийг олон янзын аргаар даван туулж байгаа боловч арилжааны банкнаас санхүүжилт авах нь хамгийн элбэг байдаг байна. Санхүүжилт авахад тулгардаг бас нэг бэрхшээл нь барьцаа хөрөнгө байдаг. Учир нь эмэгтэйчүүд өөрсдийн нэр дээр үл хөдлөх хөрөнгө бүртгүүлэхээс илүүтэй гэр бүлийн хүний нэр дээр бүртгүүлдэг байна. Энэтхэг улсын хувьд эмэгтэйчүүддээ хөрөнгө худалдан авч бүртгүүлсэн тохиолдолд шимтгэл хураамжаас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх замаар хөрөнгөтэй болохыг нь дэмжсэн хөтөлбөр явуулж байсан. Энэ нь эмэгтэйчүүд санхүүжилт хэрэгцээтэй үед хөрөнгөө барьцаалан зээл авах, бизнесийн үйл ажиллагаагаа тогтвортой явуулах боломжтой болох юм. Улс орон бүрийн онцлогоос шалтгаалан бизнес эрхлэгч эмэгтэйчүүддээ зориулсан санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээг арилжааны банкууд нэвтрүүлэн үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тухайн улсдаа үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкуудын хувьд 2-3 банк л эмэгтэй бизнес эрхлэгчдээ дэмжих тал дээр ажиллаж байна. Арилжааны банкуудаас ЖДҮ эрхлэгч нартаа зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээг гаргахдаа санхүүгийн бус үйлчилгээг давхар үзүүлж байгаа нь манай улсын арилжааны банкуудаас давуу талтай. Арилжааны банкуудын хэрэгжүүлж буй санхүүгийн бус үйлчилгээ нь нийтлэг Олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна. ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ нь барьцаа хөрөнгөгүй зээл олгох асуудлыг ихэвчлэн шийдвэрлэж, цахим хэтэвчийн үйлчилгээгээр дамжуулан бүх төрлийн үйлчилгээ авахдаа шимтгэл хураамжаас чөлөөлөх зэрэг арга хэмжээг авч байна. Кейс судалгаанаас харахад Ливан улсын BLC банк нь эмэгтэйчүүдэд зориулсан цогц үйлчилгээг гаргасан. Тус хөтөлбөр нь санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээ болох сургалт, хөгжил, зах зээлд нэвтрэх боломж, мэдээ мэдээллээр хангах, барьцаагүй зээл зэрэг үйлчилгээнүүд багтаж байна.

САНАЛ ЗӨВЛӨМЖ

Арилжааны банкуудын зүгээс Жендэрийн мэдрэмжтэй бүтээгдэхүүн үйлчилгээ гаргах, санхүүгийн мэдлэг, мэдээлэл, зөвлөх үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ шаардлага их байна. Арилжааны банкууд хүйсээр ангилсан тайлан мэдээ гарган Монгол банканд сар бүр хүргүүлж байгаа боловч дотоод тайланд хүйсээр ангилсан мэдээлэл байхгүй байна.

Банкуудын зүгээс Жижиг, дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн тогтвортой санхүүжилтийг дэмжихийн тулд дараах арга хэмжээнүүдийг авах нь үр дүнтэй гэж үзэж байна. Үүнд:

Банкууд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих санхүүгийн болон санхүүгийн бус бүтээгдэхүүн үйлчилгээг гаргахын тулд зах зээлийн судалгаа хийж, харилцагчдыгаа сегментчилэн авч үзэх:

- Харилцагчийг сегментчилэхдээ байгууллагын үйл ажиллагааны чиглэл, үйл ажиллагаа эрхэлсэн хугацаа, борлуулалтын орлого зэргийг харгалзан жендэрийг анхаарч үзэн сегментчилэх;

Сегментэл тохирсон санхүүгийн болон санхүүгийн бус бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх борлуулах;

- Жендэрийн мэдрэмжтэй санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг сегментийн шүүлтүүрээр харж, тохирсон бүтээгдэхүүнийг борлуулах, барьцаа хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх шийдлүүдийг боловсруулж санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд хүчин чармайлт гаргах;

Харилцагчид үнэ цэнэтэй, урт удаан харилцааг бий болгох, гарааны бизнес эхлүүлэх үеэс нь дэмжин санхүүжилт авахад нь туслах инкубатор төвийг байгуулах, Олон улсын болон дотоодын байгууллагуудаас санхүүжилт татах, СЭЗИС-ийн ахисан түвшний сургуультай хамтарсан төсөл хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх боломжтой.

НОМЗҮЙ

(Монгол улсад ковид-19 цар тахлын охид эмэгтэйчүүдийн нийгэм эдийн засгийн амьдралд үзүүлж буй нөлөөллийн судалгаа,НҮБ, Азийн хөгжлийн банк, 2021)

(Эдийн засгийн хөгжил, жижиг дунд үйлвэрлэлийн оруулж буй хувь нэмэр, ҮСХ, 2021)

(Бизнес эрхлэлт дэх жендэрийн статистикийн үнэлгээ, Эдийн засгийн бодлого өрсөлдөх чадварын судалгааны төв, 2021)

(Азийн сангийн эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх төсөл болон Хараат бус эмэгтэйчүүдэд Ковид-19 цар тахлын үзүүлж буй нөлөөллийн үнэлгээ, 2021)

(Монголын бичил болон жижиг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд ковид-19 цар тахлыг үзүүлж буй нөлөөллийн үнэлгээ, НҮБ, Азийн сан, 2021)

(Монгол улсын санхүүгийн салбарт жендэрийн мэдрэмжтэй санхүүжилтийн аргачлалыг нэвтрүүлэх, НҮБ-ын Хамтарсан хөтөлбөрийн хүрээнд Монголын Тогтвортой санхүүгийн холбоо , 2021)

(Жижиг, дунд үйлдвэрийн хөгжил, санхүүжилтийн байдал. Монгол банк , 2018)

(Санхүүгийн салбарын тойм Санхүүгийн зохицуулах хороо , 2021)

(Жижиг, дунд бизнесийн санхүүжилтийн ерөнхий байдал, Хөгжлийн шийдэл ТББ, 2021)

(Арилжааны банкуудад жижиг дунд үйлдвэрүүдэд олгох зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга зам. О.Алтаннавч , 2018)

(Ногоон хадгаламжийг тогтвортой санхүүгийн эх үүсвэр болгох нь, Б.Балдорж , 2021)

(Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг сайжруулах замаар ЖДҮ эрхлэгчдийн санхүүжилтийг нэмэгдүүлэх, Б.Оюунбилэг , 2022)

(The Role of Women Entrepreneurs in Establishing Sustainable Development in Developing Nations, Kalpana Ambepitiya General Sir John Kotelawala Defence University, 2016)

(Case study,banking on women entrepreneurs pays dividends at BLC bank, International Finance Corporation, 2013)

(Profit with purpose making banking on women impactful, Learnings from BLC bank Lebanon8 Garanti, Bank Romania, Garanti Bank Turkey, International Finance Corporation, 2014)

(International Finance Corporation and World bank-Exploring the opportunities for women-owned SMEs in Cambodia International Finance Corporation, 2019)

(Women entrepreneurs in Lebanon, European Union for women empowerment, 2021)

(Micro,Small, and Medium Enterprise Finance improving access to finance fo women-owned businesses in India, International Finance Corporation and in partnership with the Government of Japan, 2012)

(Women-owned enterprises in Vietnam perceptions and Potential, International Finance Corporation and World bank, Goldman Sachs, 2016)



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ

Санхүүгийн зах зээлийн сургалт, судалгааны хүрээлэн

Холбоо барих:

Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 5,

СЭЗИС, 8 давхар, 804 тоот

Утас: 7015-8821

И-мэйл: dfm@ufe.edu.mn